



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 361

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.5, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2015 оны 02-07-119/1974 дүгээр дүгнэлтээр эрсдэлтэй үнэлэгдсэн үл хөдлөх хөрөнгө болон цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нийт 53,522,468.00 (тавин гурван сая таван зуун хорин хоёр мянга дөрвөн зуун жаран найман) төгрөгийн балансын үнэтэй, 38,814,189.44 (гучин найман сая найман зуун арван дөрвөн мянга нэг зуун наян есөн төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Энхбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА *Б.Гаваа* Б.ГАВАА



Ц.НЯМ-ОСОР

0002163



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
361...дугаар тогтоолын хавсралт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 акталж, данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Балансын		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
					нэг бүрийн үнэ	нийт үнэ		
1	Автограж	Ш	1	2001.12.01	35 000 000,00	35 000 000,00	20 291 721,44	14 708 278,56
2	Зүлэгний машин	Ш	1	2007.12.26	245 000,00	245 000,00	245 000,00	-
3	Файл хадгалах төхөөрөмж	Ш	1	2010.12.30	1 900 000,00	1 900 000,00	1 900 000,00	-
4	Эйр кондишн	Ш	3	2008.08.11	563 000,00	1 689 000,00	1 689 000,00	-
5	Кофений машин	Ш	1	2012.12.31	8 600 000,00	8 600 000,00	8 600 000,00	-
6	Ус цэвэрлэгээний төхөөрөмж	Ш	1	2011.06.25	6 088 468,00	6 088 468,00	6 088 468,00	-
						53 522 468,00	38 814 189,44	14 708 278,56
	Нийт дүн		8			(тавин гурван сая таван зуун хорин хоёр мянга дөрвөн зуун жаран найман)	(гучин найман сая найман зуун арван дөрвөн мянга нэг зуун наян есөн төгрөг дөчин дөрвөн мөнгө)	(арван дөрвөн сая долоон зуун найман мянга хоёр зуун далан найман төгрөг тавин зургаан мөнгө)